Баян-Олгий аймгийн Олгий сумын «Жан Шарапат» эмнэлэгт vйлчлэх хvрээгээ оргожvvлэн, оношлогоо, эмчилгээг чанартай хийж байгааг нь vнэлж хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс «Хэрэглэгчдийн найдвартай тvнш» оргомжлол гардууллаа. Их эмч А.Айжан эзэнтэй энэ эмнэлэг энэ жил арван таван жилийнх нь ой болж байгаа богоод дотрын овчин эмгэгийг анагаах чиглэлийг дагнан дорвон их эмч, таван сувилагч, нийт арван таван ажиллагсадтайгаар ажил vйлчилгээ явуулж байна. Анагаахын сvvлийн vеийн тоног тохооромжvvдээр тоноглогдсон. Тусгай амбулатори, дочин орны багтаамж бvхий эмнэлгийн байртай. Хот ходооноос хvмvvс тасралтгvй ирж овчноо шинжлvvлэн, эмчлvvлж байдаг. Арав хоног хэвтэж эмчлvvлэхэд хvн бvр орны зэрэглэлээс хамааран 140-180 мянган тогрог толдгийн 50 хувийг даатгалаас даадаг. Овчтонvvдэд одорт таван удаа чанартай хоол огдог. Баттай оношлогоо, чанартай эмчилгээ, соёлч боловсон vйлчилгээг гол зорилтоо болгон ажилладаг ажээ.